



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 11 дугаар сарын 13

Дугаар 03/03

Баян-Өндөр сум

**Ойгоос бэлтгэх модны дээд хэмжээ  
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/699 дүгээр тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн 2018 оны ойн зохион байгуулалтын ажлын тайлан, ойн менежмент төлөвлөгөөг харгалзан 2025 онд Жаргалант сумын хэмжээнд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг 900 шоо метрээр баталж, дараах хэмжээгээр тогтоосугай.

- 1.1. Ойн цэвэрлэгээний ажлаар хэрэглээний хуурай шинэс мод 100 шоо метр;
- 1.2. Түлээний шинэс мод 800 шоо метр.

2. Холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу ойгоос бэлтгэх модны төрөл тоо, хэмжээг нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага тус бүрээр тогтоохыг Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨНХБАТ